



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Туулын хишиг” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СЭА-2026/014/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.open.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,	
	тэргүүлэх аудитор:	Б.Батмөнх
	Утас: 70363040	Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
	Ахлах аудитор :	Ц.Отгонбаяр
	Утас: 70363036	Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn
	Аудитыг гүйцэтгэсэн:	Пийк Ом Аудит ХХК
Аудитор	А.Мөнхцэцэг	
Утас: 99041628	Цахим хаяг: peakomauditllc@gmail.com	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт.....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	10
Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	11
3.1 Албан шаардлага.....	11
Дөрөв.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	0

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ТБОНОХБАХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



“ТУУЛЫН ХИШИГ” ОНӨААТҮГ-ЫН

ДАРГА Х.ГАНБАТ ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № СЭА-2026/014-НА-СТА-ОНӨУГ

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Туулын хишиг ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Туулын хишиг ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар дараах зөрчлүүд илэрсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.1 Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Тайлант оны үйл ажиллагааны үр дүнгээр 76,813.9 мянган төгрөгийн алдагдал хүлээж, өөрийгөө санхүүжүүлж чадаагүй,
- Татварын өглөгийг 1,446.5 мянган төгрөгөөр дутуу тусгасан,
- Эрх бүхийн байгууллагын шийдвэргүйгээр 2009 онд үүссэн харилцагч нь тодорхой бус, олон жил дамнасан, насжилт өндөртэй мянган 27,268.1 төгрөгийн авлагыг бүртгэлээс хассан,

4326050340₂

- Шинэ жилийн арга хэмжээнд 725.0 мянган төгрөгийг зарцуулсан,

Асуудлыг онцолсон хэсэг

Орхонтуул суманд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдээс нийгмийн хариуцлагын хүрээнд 74,200.0 мянган төгрөгийн хандив, сумын Онцгой комиссын шийдвэрээр ЗДНХ-өөс халаалтын шугамын засварт 18,000.0 мянган төгрөгийн дэмжлэг авсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд гүйцэтгэлээр айл өрхөөс 16.885.4 сая төгрөгийн, аж ахуйн нэгжээс 8.077.5 сая төгрөг, төсөвт байгууллагуудаас 288.020.3 сая төгрөгийн зэрэг нийт 312,983.2 сая төгрөгийн борлуулалтын орлого бүрдүүлэн 481,997.1 сая төгрөгийн зардал гарган, 76,813.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. .

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

“Туулын хишиг” ОНӨААТҮГ-ын 2025 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 95.0 хувийн хэрэгжилттэйгээр тайлагнасан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *B. Batmunkh* Б.БАТМӨНХ



Хоёр. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/д	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	634,493.00	318,249.38
2	Дансны авлага	75,045,768.05	44,752,574.70
3	Татвар, НДШ-ийн авлага	-	-
4	Бусад авлага	-	-
5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
6	Бараа материал	8,662,859.24	13,119,638.24
7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	-
8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн хөрөнгө(борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
10	Эргэлтийн хөрөнгийн дүн	84,343,120.29	58,190,462.32
11	Үндсэн хөрөнгө	417,163,203.95	403,516,807.49
12	Биологийн хөрөнгө	-	-
13	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
14	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
15	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
16	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
17	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
18	Биет бус хөрөнгө	1,484,696,000.00	1,484,696,000.00
19	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,901,859,203.95	1,888,212,807.49
20	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,986,202,324.24	1,946,403,269.81
21	Дансны өглөг	92,019,766.73	130,445,503.38
22	Цалингийн өглөг	-	12,296,761.00
23	Татварын өр	50,448,065.30	64,008,558.09
24	НДШ-ийн өглөг	0.34	-
25	Богино хугацаат зээл	-	-
26	Банкны зээлийн хүүгийн өглөг	-	-
27	Ногдол ашгийн өглөг	-	-
28	Урьдчилж орсон орлого	-	-
29	Нөөц(өр төлбөр)	-	-
30	Бусад богино хугацаат өр төлбөр	-	-
31	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгөд хамаарах өр	-	-
32	Богино хугацаат өр төлбөрийн дүн	142,467,832.37	206,750,822.47
33	Урт хугацаат зээл	-	-
34	Нөөц(өр төлбөр)	-	-
35	Хойшлогдсон татварын өр	-	-
36	Бусад урт хугацаат өглөг	-	-
37	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
38	Өр төлбөрийн нийт дүн	142,467,832.37	206,750,822.47
39	Өмч: а) төрийн	2,118,488,000.00	2,118,488,000.00

40	б) хувийн	-	-
41	в) хувьцаат	-	-
42	Халаасны хувьцаа	-	-
43	Нэмж төлөгдсөн капитал	-	-
44	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	164,604,304.98	164,604,304.98
45	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
46	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	-	-
47	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	-439,357,813.11	-543,439,857.64
48	Эздийн өмчийн дүн	1,843,734,491.87	1,739,652,447.34
49	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,986,202,324.24	1,946,403,269.81

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	317,783,838.87	405,183,178.40
2	Борлуулалтын өртөг	362,282,580.67	386,924,219.81
3	Нийт ашиг	-44,498,741.80	18,258,958.59
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	15,000,000.00	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	61,111,532.16	93,006,655.32
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	404,300.00	2,066,200.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг алдагдал	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-91,014,573.96	-76,813,896.73
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татвар дараах ашиг (алдагдал)	-91,014,573.96	-76,813,896.73
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-91,014,573.96	-76,813,896.73
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
24	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
25	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
26	Бусад олз (гарз)	-	-
27	Орлогын нийт дүн	-	-
28	Нэгж хувьцааны ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2024. оны 1-р сарын 01-ний үлдэгдэл	2,118,488,000.00	164,604,304.98	-368,343,239.15	1,914,749,065.83
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө алдааны залруулга	-	-	20,000,000.00	20,000,000.00
3	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
4	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал /	-	-	-91,014,573.96	-91,014,573.96
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
9	2024 оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл	2,118,488,000.00	164,604,304.98	-439,357,813.11	1,843,734,491.87
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө алдааны залруулга	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
12	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал /	-	-	-76,813,896.73	-76,813,896.73
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-27,268,147.80	-27,268,147.80
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
17	2025 оны 12- р сарын 31-ний үлдэгдэл	2,118,488,000.00	164,604,304.98	-543,439,857.64	1,739,652,447.34

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2	Мөнгөн орлогын дүн (+)	360,914,752.28	420,774,365.82
3	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	17,000,800.00	76,320,000.00
4	Эрхийн шимтгэл, хураамж төлбөрийн орлого	-	-
5	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
6	Буцаан авсан албан татвар	-	-
7	Татаас санхүүжилтийн орлого	-	-
8	Бусад мөнгөн орлого	343,913,952.28	344,454,365.82
9	Мөнгөн зарлагын дүн (-)	361,864,475.25	421,203,409.44
10	Ажиллагчдад төлсөн	99,544,742.00	135,356,691.29
11	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	33,330,717.40	42,493,836.00
12	Бараа материалын худалдан авахад төлсөн	-	159,811,890.00
13	Ашиглалтын зардалд төлсөн	-	57,900,000.00
14	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	70,000.00	81,000.00
15	Хүүний төлбөрт төлсөн	-	500,000.00
16	Татварын байгууллагад төлсөн	7,140,967.85	16,613,372.15
17	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
18	Бусад мөнгөн зарлага	5,642,050.00	8,446,620.00
19	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-911,246.97	-316,243.62
20	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
21	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
22	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	-	-
23	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
24	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
25	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
26	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
27	Хүлээн авсан хүүний орлого	-	-
28	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
29		-	-
30	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
31	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
32	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
33	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
34	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
35	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
36		-	-
37	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
38	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
39	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
40	Зээл, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
41	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
42	Төрөл бүрийн хандив	-	-
43		-	-

44	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
45	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-	-
46	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
47	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
48	Төлсөн ногдол ашиг	-	-
49	Бусад зарлага	-	-
50	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
51	Валютын ханшийн зөрүү	-	-
52	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-911,246.97	-316,243.62
53	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,545,739.97	634,493.00
54	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	634,493.00	318,249.38

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Хэм/ нэгж	2024 оны гүйцэтгэл	2025 он		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Нийт борлуулалт		332,787.80	310,110.70	405,183.20	-95,072.50	130%
	Үүнээс цэвэр борлуулалт	м/төг	332,787.80	310,110.70	405,183.20	-95,072.50	130%
	Төсвийн байгууллага	м/төг	288,270.80	277,141.00	288,020.30	-10,879.30	104%
	айл өрх	м/төг	17,728.30	19,681.00	16,885.40	2,795.60	86%
	ААН	м/төг	11,788.70	11,788.70	8,077.50	3,711.20	66%
2	Хандив тусдамжийн орлого	м/төг	15,000.00	1,500.00	92,200.00	-90,700.00	
3	нийт зардал		423,802.30	511,964.10	481,997.10	29,967.00	94%
	Үүнээс: а/Борлуулалтын өртөг	м/төг	362,282.60	416,314.10	386,924.20	29,389.90	
	б/ Ерөнхий удирдлагын зардал		61,519.70	95,650.00	95,072.90	577.10	
3	Цэвэр ашиг. алдагдал	м/төг	-91,014.50	-201,853.40	-76,813.90		

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Залруулга

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой дараах 16,382.7 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн тайланд тусгасан борлуулалтын орлогын дүн татварын цахим системд тайлагнасан дүнгээс 16,382.7 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд СТОУС-1 “*Санхүүгийн тайлангийн толилуулга*” стандарт болон “*Үнэлгээ ба хуваарилалт*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 106,253.5 мянган төгрөгийн 3 зөрчил илэрч зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **106,253.5** мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 103,015.6 мянган төгрөгөөр давсан тул “**Хязгаарлалттай**” дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

1. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр дараах зөрчлүүдийг давтан гаргасан байна. Үүнд :

- МТА-ны "Байгууллагын татварын тодорхойлол"-д НӨАТ-ын өглөгийг 1,446.5 мянган төгрөгөөр дутуу тусгасан байна,
- Тайлант онд үйл ажиллагааны үр дүнгээр 76,813.9 мянган төгрөгийн алдагдал хүлээж, өөрийгөө санхүүжүүлж чадаагүй бөгөөд үйл ажиллагаа явуулах тусам алдагдлын хэмжээ нэмэгдсэн.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дэх “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь “*Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэнэ.....*” 18 дугаар зүйлийн 18.1 дэх “*Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

2. Эрх бүхийн байгууллагын шийдвэргүйгээр 2009 онд үүссэн харилцагч нь тодорхой бус, олон жил дамнасан, насжилт өндөртэй 27,268.1 мянган төгрөгийн авлагыг бүртгэлээс хассан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана" 20 дугаар зүйлийн 20.1 дэх "Захирал дараах эрх, үүрэгтэй" 20.1.2 үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд **хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах**" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн авлагыг данс бүртгэлээс хасах албан шаардлага хүргүүлэв.

3. Тус байгууллага нь шинэ жилийн арга хэмжээнд 725.0 мянган төгрөгийн зардал гаргасан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.3 "Үр ашигтай байх", 12 дугаар зүйлийн 12.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно: 12.1.4.хуулиар зөвшөөрөөгүй бусад" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Борлуулалтын орлогын дүн татварын цахим системд зөрүүтэй тайлагнасан.	1	16,382.7			1	16,382.7	1	16,382.7				
Дүн	1	16,382.7			1	16,382.7	1	16,382.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Жил бүр алдагдалтай ажиллаж хуримтлагдсан алдагдлын хэмжээ нэмэгдсэн	1	76,813.9			1	76,813.9						
Татварын өрийн үлдэгдэл зөрүүтэй илэрхийлэгдсэн	1	1,446.5			1	1,446.5						
Эрх бүхийн байгууллагын шийдвэргүйгээр насжилт өндөртэй авлагыг бүртгэлээс хассан байна.	1	27,268.1			1	27,268.1						
Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй	1	725.0			1	725.0						
Дүн	4	106,253.5			4	106,253.5						

